



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

477.	Засгийн газрын бүтцийн тухай	1917
478.	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай	1917
479.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1919
480.	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1926
481.	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1926
482.	Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1927
483.	Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1928
484.	Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1929
485.	Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1932
486.	Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1932
487.	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1933
488.	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1934
489.	Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1935
490.	Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1938
491.	Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1940



492.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1940
493.	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1942
494.	Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1943
495.	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1945
496.	Бисийн тамир, спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1947
497.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1948
498.	Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуульд нэмэлт оруулах тухай	1949
499.	Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1949
500.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1950
501.	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1950
502.	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1950
503.	“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1951



504.	Хувийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1951
505.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1952
506.	Инновацийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		1952
507.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1953
508.	Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1953
509.	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1953
510.	Концессын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1954
511.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1954
512.	Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1955
513.	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		1955
514.	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1956
515.	Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай		1956
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
516.	Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай	Дугаар 12	1957
517.	Өргөдлийн байнгын хорооны даргыг сонгох тухай	Дугаар 13	1957



518.	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай	Дугаар 14	1958
519.	Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 15	1960
520.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 16	1960
521.	Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай	Дугаар 17	1961
522.	Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай	Дугаар 18	1962
523.	Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 19	1964
524.	Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг томилох тухай	Дугаар 20	1964
525.	Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай	Дугаар 21	1965
526.	Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 22	1966
527.	Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай	Дугаар 23	1966
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ			
528.	Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 200	1969



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮТЦИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн

- 1/Байгаль орчин, ногоон хөгжлийн яам;
- 2/Гадаад харилцааны яам;
- 3/Сангийн яам;
- 4/Хууль зүйн яам;

Чиглэлийн

- 5/ Барилга, хот байгуулалтын яам;
- 6/ Батлан хамгаалах яам;
- 7/ Боловсрол, шинжлэх ухааны яам;
- 8/ Зам, тээврийн яам;
- 9/ Соёл, спорт, аялал жуулчлалын яам;
- 10/ Уул уурхайн яам;
- 11/ Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам;
- 12/ Хөдөлмөрийн яам;
- 13/ Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам;
- 14/ Эдийн засгийн хөгжлийн яам;
- 15/ Эрчим хүчний яам;
- 16/ Эрүүл мэндийн яам.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 16-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүнийг дор дурдсанаар тогтоосгай:



- 1/Монгол Улсын Ерөнхий сайд;
2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайд;
3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд;
5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайд;
6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайд;
7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүйн сайд;
8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайд;
9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайд;
10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, шинжлэх ухааны сайд;
11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайд;
12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлалын сайд;
13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Уул уурхайн сайд;
14/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд;
15/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөрийн сайд;
16/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд;
17/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эдийн засгийн хөгжлийн сайд;
18/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайд;
19/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайд.



2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/18 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

Ерөнхий чиг үүргийн

- 1/Байгаль орчин, ногоон хөгжлийн яам;
- 2/Гадаад харилцааны яам;
- 3/Сангийн яам;
- 4/Хууль зүйн яам;

Чиглэлийн

- 5/Барилга, хот байгуулалтын яам;
- 6/Батлан хамгаалах яам;
- 7/Боловсрол, шинжлэх ухааны яам;
- 8/Зам, тээврийн яам;
- 9/Соёл, спорт, аялал жуулчлалын яам;
- 10/Уул уурхайн яам;
- 11/Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам;
- 12/Хөдөлмөрийн яам;
- 13/Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам;
- 14/Эдийн засгийн хөгжлийн яам;
- 15/Эрүүл мэндийн яам;
- 16/Эрчим хүчний яам.”

2/20 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

“4.Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудал хамаарна:



- улсын тогтвортой хөгжлийн бодлого;
- улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого;
- мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны асуудал;
- тагнуул, сөрөг тагнуул, терроризмаас урьдчилан сэргийлэх асуудал;
- цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах асуудал;
- газар зохион байгуулалт болон усны нэгдсэн бодлого;
- жендерийн хөгжлийн асуудал.

5.Засгийн газрын гишүүн дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ:

1/Монгол Улсын Шадар сайд:

- гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх асуудал;
- хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаатай холбоотой шуурхай асуудал;
- тодорхой салбарын мэргэжлийн хяналтын асуудал;
- стандартчилал, хэмжил зүйн асуудал;
- шударга өрсөлдөөнийг дэмжих, хянан зохицуулах асуудал;
- хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудал;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа;
- оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал.

2/Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга:

- шинэтгэлийн бодлого;
- орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого;
- төрийн албаны хүний нөөцийг давтан сургах асуудал;
- Засгийн газрын шийдвэрийн биелэлт;
- Засгийн газрын дотоод мэдээлэл;
- Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах асуудал;
- орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, удирдлага;
- иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд үзүүлэх мэргэжил, арга зүйн туслалцаа;
- Засаг даргын үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах асуудал.



3/Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд:

- байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;
- цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;
- усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал;
- ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал, мэдээллийн сан;
- байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал;
- биоаюулгүй байдлын бодлогын асуудал;
- ногоон хөгжлийн бодлого.

4/Гадаад харилцааны сайд:

- гадаад улс, олон улсын байгууллагатай улс төрийн талаарх хамтын ажиллагаа;
- гадаад эдийн засгийн харилцаа;
- гадаадад байгаа Монгол Улсын иргэд, бизнесийн эрх ашгийг хамгаалах асуудал;
- дипломат, албан зэргийн виз, консулын асуудал;
- гадаад улс, олон улсын байгууллагатай хүмүүнлэгийн чиглэлээрх хамтын ажиллагаа;
- гадаад улс, олон улсын байгууллагатай хийх гэрээ, хэлэлцээрийн асуудал болон байгуулсан гэрээ, хэлэлцээрийн явцад тавих хяналт;
- гадаад сурталчилгаа.

5/Сангийн сайд:

- нэгдсэн төсвийн талаарх судалгаа, төлөвлөлт;
- улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын хяналт;
- нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- гаалийн бодлого;
- татварын бодлого;
- даатгалын бодлого;
- санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн удирдлагын асуудал;
- төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагаа;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах бодлого.



6/Хууль зүйн сайд:

- эрх зүйн шинэтгэлийн бодлого;
- хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;
- эрх зүйн туслалцаа;
- архивын талаар төрөөс баримтлах бодлого;
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
- энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;
- иргэний харьяалал, цагаачлалын асуудал;
- улсын хил хамгааллын асуудал;
- хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүртгэл;
- төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;
- Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, хуульчдын олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;
- цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;
- төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт;
- иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл.

7/Батлан хамгаалахын сайд:

- улсыг батлан хамгаалах бодлого болон цэргийн бодлого;
- зэвсэгт хүчнийг чадваржуулах бодлого;
- энхийг дэмжих ажиллагаанд оролцох бэлтгэл хангуулах асуудал.

8/Барилга, хот байгуулалтын сайд:

- барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого;
- хот төлөвлөлт болон хот байгуулалтын бодлого, архитектурын асуудал;
- орон сууцны бодлогын асуудал;
- нийтийн аж ахуйн асуудал;
- газрын харилцаа, геодези, зураг зүйн асуудал.

9/Боловсрол, шинжлэх ухааны сайд:

- боловсролын тогтолцоог хөгжүүлэх асуудал;
- ном хэвлэл, цахим бичвэрийн бодлого;



- шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын асуудал;
- шинжлэх ухаан, технологийн мэдээлэл.

10/Зам, тээврийн сайд:

- тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зохицуулалт;
- төмөр замын тээврийн асуудал;
- иргэний нисэхийн асуудал;
- авто тээврийн асуудал;
- авто замын асуудал;
- далай ашиглах болон усан замын тээврийн асуудал.

11/Соёл, спорт, аялал жуулчлалын сайд:

- соёл, урлагийг хөгжүүлэх асуудал;
- түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх бодлого;
- нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого;
- мэргэжлийн спортын хөгжлийн асуудал;
- аялал жуулчлалын бодлого.

12/Уул уурхайн сайд:

- геологи, эрдэс баялгийн бодлого;
- газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого;
- олборлох үйлдвэрийн техник, технологийн асуудал;
- ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх бодлого.

13/Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд:

- хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн бодлогын асуудал;
- аж үйлдвэрийн паркийн асуудал;
- төрийн өмчийн бодлого;
- хүн амын хүнсний хангамжийн бодлого;
- хүнсний аюулгүй байдлын асуудал;
- мал аж ахуй болон газар тариаланг эрчимжүүлэн хөгжүүлэх бодлого;
- мал эмнэлэг, малын үржлийн талаар төрөөс явуулах бодлого;
- мал, амьтан, ургамлын хорио, цээрийн асуудал;
- бэлчээрийн болон таримал ургамлыг хамгаалах асуудал;
- мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эдийн экспорт, импортын асуудал;



- хөдөө аж ахуйн эдэлбэр газрын болон бэлчээр ашиглалтын бодлого;
- малыг цаг агаарын гэнэтийн аюулаас хамгаалах бодлого.

14/Хөдөлмөрийн сайд:

- хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг багасгах, ядуурлыг бууруулах бодлого;
- хөдөлмөрийн нөхцөл, ажиллагчдын цалин, амьдралын өртгийн талаарх асуудал;
- хөдөлмөрийн харилцаа, Засгийн газар, эзэд, Үйлдвэрчний эвлэлийн гурван талт түншлэл, хөдөлмөрийн хамтын маргааны зохицуулалтын асуудал;
- хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт;
- хөдөлмөрийн биржийн асуудал;
- Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэний асуудал;
- гадаадад ажиллах хүч гаргах асуудал;
- жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийн асуудал;
- мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн тогтолцоог хөгжүүлэх асуудал.

15/Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд:

- хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал;
- хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадын болон гэр бүлийн хөгжлийн асуудал;
- нийгмийн халамжийн бодлого;
- нийгмийн даатгалын бодлого;
- хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн асуудал.

16/Эдийн засгийн хөгжлийн сайд:

- хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого;
- улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийн асуудал;
- улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хөгжлийн төлөвлөлт хийх, салбар хоорондын бодлогын уялдааг хангах асуудал;
- эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоох асуудал;



- зээл, тусламжийн нэгдсэн бодлого;
- худалдааны бодлого, зохицуулалт;
- экспорт, импортын асуудал;
- гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалт, бүртгэл;
- эдийн засгийн хамтын ажиллагааны нэгдсэн бодлого, зохицуулалт;
- өндөр технологи, үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал
- чөлөөт бүсийн хөгжлийн асуудал;
- концесс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодлого.

17/Эрчим хүчний сайд:

- эрчим хүчний нэгдсэн бодлого;
- эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал;
- сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал;
- эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого.
- түлш /эрчим хүчний нүүрс/-ний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалт.

18/Эрүүл мэндийн сайд

- хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нөхөн сэргээх бодлого;
- эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамжийн талаарх бодлого;
- эмнэлгийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судлалын хүрээний бодлого;
- хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн болон мэргэжлийн арга хэмжээ.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18² дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “14-т заасан” гэснийг “2-т заасан” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.1.Агентлагийн орон тооны дээд хязгаарыг Засгийн газар, агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг Засгийн газраас тогтоосон ерөнхий загварыг баримтлан Монгол Улсын сайд батална.”

2 дугаар зүйл.Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.11 дэх заалтын “сайдаас” гэснийг “энэ хуулийн 9.1-д заасны дагуу” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалт, 13 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 13.1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 28.2-28.4, 28.6, 28.9 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.11 дэх хэсгийн “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга” гэснийг “санхүү, төсвийн болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд” гэж өөрчилсүгэй.



3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.1.9-6.1.13 дахь заалт нэмсүгэй:

“6.1.9.автотээврийн талаар төрөөс баримтлах бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг шалгах, дүнг мэдээлэх;

6.1.10.улс хоорондын зорчигч болон ачаа тээвэр, нийтийн тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ болон автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх ажлыг зохион байгуулах;

6.1.11.тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

6.1.12.Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтлөх үйл ажиллагааг зохион байгуулах;

6.1.13.хуульд заасан бусад бүрэн эрх.”

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллагын бүтцэд” гэснийг “Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 6¹ дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.



5 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 4-9 дэх заалт нэмсүгэй:

“4/гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөл бололцоог судлах, гадаад сурталчилгааны ажлыг зохион байгуулах, мэдээллээр хангах, төслийн тендерт гадаадын хөрөнгө оруулагчийг татан оролцуулах;

5/гадаадын хөрөнгө оруулагчид “нэг цэг”-ийн иж бүрэн үйлчилгээ үзүүлэх;

6/хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, нийгмийн даатгал, гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудаас гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дараах статистик мэдээллийг хагас, бүтэн жилээр авч нэгдсэн сан хөтлөх:

- а/хөрөнгө оруулалтын хэмжээ /өөрийн хөрөнгө/;
- б/татвар төлөлт;
- в/нийгмийн даатгалын шимтгэл төлөлт;
- г/ажлын байрны тоо;
- д/гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл;
- е/экспорт, импортын хэмжээ, нэр, төрөл.

7/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг хянан шийдвэрлэх;

8/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн зогсоох;

9/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.”



2 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1, 4, 6, 10, 11 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн гарчиг, 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1/ гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх нэгдсэн зорилттой уялдуулан боловсруулах, хэрэгжүүлэх;”

4 дүгээр зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллагын дарга” гэснийг “Засгийн газрын гишүүн” гэж, 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь” гэснийг “Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Соёлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхтэй байна:



1/төрөөс соёлын талаар баримтлах бодлого, соёлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;

2/хууль тогтоомжийн хүрээнд түүнийг хэрэгжүүлэх зорилгоор соёлын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг батлан гаргах;

3/улсын чанартай болон орон нутгийн төрийн өмчийн соёлын байгууллагын оновчтой сүлжээ, бүтцийг бий болгож ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4/соёлын байгууллагыг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

5/түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах, үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх;

6/эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, уран сайхан, гоо зүйн хүмүүжил олгох бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

7/олон улсын болон улсын чанартай соёлын арга хэмжээ зохион байгуулах, соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

8/дайн, түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглох арга хэмжээ авах;

9/соёлын тоо бүртгэл хөтөлж, дүн шинжилгээ хийх;

10/соёлын салбарт мэргэжлийн хүний нөөц бэлтгэх арга хэмжээ авч, аймаг, нийслэлийн соёл, урлагийн байгууллагыг мэргэжлийн ажиллах хүчнээр хангахад дэмжлэг үзүүлэх, соёлын ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

11/кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

12/соёл судлалыг хөхүүлэн дэмжих;

13/хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгох соёл, урлагийн бүтээлийн зэрэглэл, жагсаалт, хэрэгжүүлэх журмыг тогтоох;



14/Монгол Улсад шинээр хэвлэгдэн гарч байгаа ном, хэвлэлийн бүтээгдэхүүн тус бүрээс хоёроос доошгүйг шалгаруулалт хийсний үндсэн дээр улс, аймаг, нийслэлийн төв номын санд худалдан авах. Шалгаруулалт хийх, худалдан авах журмыг Засгийн газар тогтооно;

15/түүх, соёлын дурсгалт зүйлийг судалж шинжлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, ашиглалт, хамгаалалтад хяналт тавих ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, гадаад, дотоодод үзэсгэлэн гаргах ажлыг зохион байгуулах;

16/утга соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, хамгаалах, өвлүүлэх, судалж сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах, утга соёлын өвийг өвлөн тээгч билиг авьяастныг судлан тодорхойлж, эрдэм авьяасыг нь хойч үед уламжлуулахад туслан дэмжлэг үзүүлэх;

17/ардын язгуур урлагийн чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

18/дүрслэх урлаг, дизайны чиглэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

19/соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

20/хуульд заасан бусад бүрэн эрх.”

2 дугаар зүйл.Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын “холбогдох” гэснийг “төв” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Соёлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн “Соёл, урлагийн хороо,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Соёлын тухай хуулийн 13¹дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5.3.6, 5.3.7 дахь заалт нэмсүгэй:

“5.3.6.сэргээгдэх эрчим хүчний нөөцийн судалгаа хийх;

5.3.7.сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, техник хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар, үйлчилгээний стандартыг боловсруулж, зохих журмын дагуу батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих.”

2 дугаар зүйл. Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 6.1.12-6.1.16 дахь заалт нэмсүгэй:

“6.1.12.эрчим хүч, түүний нөөцийг ашиглах, импортлох, экспортлох, эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барих талаарх төрийн бодлого боловсруулахад шаардагдах тооцоо, үнэлгээ, дүн шинжилгээ хийх;

6.1.13.эрчим хүчний салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.14.эрчим хүчний шинэ эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах;



6.1.15.уламжлалт бус эрчим хүчний эх үүсвэрийн талаар судалгаа хийх, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах;

6.1.16.эрчим хүчний алдагдлыг бууруулах, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал боловсруулах.”

2 дугаар зүйл. Эрчим хүчний тухай хуулийн 6¹ дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтын “холбогдох” гэсний дараа “төв” гэж, 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх хэсгийн “эмийн” гэсний дараа “асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “байгууллагын дэргэдэх эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 8.1.16-8.1.23 дахь заалт нэмсүгэй:

“8.1.16.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эрүүл мэндийн байгууллага, үйлдвэрлэлийн стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батлах;

8.1.17.эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах;

8.1.18.эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулах;

8.1.19.эрүүл мэндийн статистик мэдээллийг нэгтгэн гаргах, мэдээлэх;

8.1.20.эрүүл мэндийн салбарын хөгжил, эрүүл мэндийн ажилтны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах, судалгаа хийх;

8.1.21.иргэний эрүүл мэндээ хамгаалах, өвчлөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх, эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг зохион байгуулах;

8.1.22.эмийг бүртгэх, баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулж, эмийн чанар, аюулгүй байдлын талаар нийтэд мэдээлэх;

8.1.23.эрүүл мэндийн ажилтныг төгсөлтийн дараах сургалтад хамруулах, мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулах;”

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.16 дахь заалтын дугаарыг “8.1.24” гэж өөрчилсүгэй.



4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “болон төрийн захиргааны” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 13.1.17-13.1.34 дэх заалт нэмсүгэй:

“13.1.17.ой, хээрийг түймэр, хөнөөлт шавжийн тархалт, ойн нөөцийн хомсдол, газрын доройтол, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, ойн ашиглалттай холбоотой гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих;

13.1.18.аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;

13.1.19.мод бэлтгэсэн, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, говь, хээрийг ойжуулах, ойн зурвас байгуулах, төв, суурин газрыг цэцэрлэгжүүлэх ажлыг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулах;

13.1.20.мод, сөөгийн үрийн нөөцийн сан бүрдүүлэх, мод үржүүлгийн газар байгуулах, тарьц, суулгац ургуулах ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн удирдлагаар хангах;

13.1.21.орон нутаг дахь ойн анги, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

13.1.22.ойн ангийн ажиллах журам, дүрмийг батлах;



13.1.23.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийг тайлагнах;

13.1.24.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар технологи, норм, нормативын үндэслэл боловсруулах, батлах;

13.1.25.ойн нөөцийн өөрчлөлтөд хяналт, шинжилгээ хийх, ойн мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах болон аж ахуйн нэгж, байгууллага мэргэжлийн түвшинд үйл ажиллагаа явуулахад тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах;

13.1.26.ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх ажилд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагыг оролцуулахад бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэх;

13.1.27.ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын явуулах үйл ажиллагааны хөтөлбөр, ойн ангийн эрхлэх ажил, үйлчилгээний чиглэл, ойн менежментийн төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, тэдгээрийг боловсруулах заавар, журам батлах;

13.1.28.хамгаалалтын бүсийн ойг цэвэрлэх, арчлах, түймрийн шороон болон халз зурвас гаргах зэрэг ой, хээрийн түймрээс хамгаалах ойн аж ахуйн арга хэмжээг улсын хэмжээнд төлөвлөж, шаардагдах зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулах замаар хэрэгжүүлэх;

13.1.29.ой, хээрийн түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг сурталчлах, иргэд, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ой, хээрийн түймэр унтраах арга, ажиллагаанд сургах ажлыг онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

13.1.30.ой, хээрийн түймрийн аюултай үед ой, хээрийн түймрээс сэрэмжлүүлэх, орон нутагт эргүүл, харуул ажиллуулах болон энэ ажилд бүх нийтийг татан оролцуулах талаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах;

13.1.31.ой, хээрийн түймрийн аюултай үед тухайн бүс нутгийн түймрийн аюулын анги, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаль орчинтой харьцах тодорхой үйл ажиллагааг зогсоох тухай саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;



13.1.32.нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ой, хээрийн түймрээс хамгаалах талаар зохион байгуулж байгаа ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, хамтран оролцох;

13.1.33.ой, хээрийн түймрийн гаралт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай зарлан мэдээлэх;

13.1.34.өөрийн байгууллагын бүтцэд ойн судалгаа, хяналт шинжилгээний алба ажиллуулах;"

2 дугаар зүйл.Ойн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2.3, 17.2.4, 17.3.1, 17.3.4 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.2.4 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн "төрийн захиргааны" гэсний дараа "төв" гэж, 13 дугаар зүйлийн 13.1.13 дахь заалтын "батлах" гэсний өмнө "боловсруулах," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Ойн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"10.2.Энэ хуулийн 10.1-д заасан журмыг холбогдох газрын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

4 дүгээр зүйл.Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн гарчгийг "Ойн асуудал эрхэлсэн нэгж" гэж, мөн зүйлийн 14.1 дэх хэсгийн "Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/, аймаг" гэснийг "Аймаг," гэж, 13 дугаар зүйлийн 13.1.17 дахь заалтын дугаарыг "13.1.35" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2 дахь заалтын "төрийн захиргааны болон" гэснийг хассугай.

6 дугаар зүйл.Ойн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуулийн 10 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 10.1.14-10.1.29 дэх заалт нэмсүгэй:

“10.1.14.усны хайгуул, зураг төсөл, судалгааны төлөвлөгөө боловсруулж батлах, хэрэгжүүлэх, хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавих;

10.1.15.усны ашиглах боломжит нөөцийн хэмжээг сав газрын хэмжээнд ашиглалтын зориулалт бүрээр тогтоон боловсруулах, мөрдүүлэх;

10.1.16.энэ хуулийн 4.9-д заасан усны нөөцийн дээд хязгаарыг тогтоох санал боловсруулах;

10.1.17.улсын усны мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх, усны төлөв байдалтай холбогдолтой мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах;

10.1.18.улсын усны тоо бүртгэл, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулах, усны нөөц, ус ашиглалтын тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах;

10.1.19.усны экологи-эдийн засгийн үнэлгээг тооцох аргачлал, зааврыг боловсруулах, усны нөөцөд учруулсан хохирлыг тооцох;

10.1.20.ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартыг дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.21.сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн байгаль хамгаалагчийг усны харилцааны талаарх нэгдмэл удирдлагаар хангах, энэ хуулийн 28.4-т заасны дагуу гаргасан сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны албаны дүгнэлт, түүнчлэн усны мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд хяналт тавих;

10.1.22.голын голдирлыг өөрчлөх, урсацад тохируулга хийх, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргах;



10.1.23.цооног өрөмдөх, худаг гаргах, усны барилга байгууламж барих, ашиглах судалгаа хийх, дүгнэлт гаргах;

10.1.24.ган, цөлжилт, хуурайшилтын үед усны нөөц хомсдох, бохирдсон тохиолдолд тухайн сав газарт ус ашиглагчийн ашиглах усыг хуваарилах, хязгаарлах, ус, түүний орчныг нөхөн сэргээх зорилгоор ус ашиглахыг тодорхой хугацаагаар түр хориглох;

10.1.25.рашааны эмчилгээний чанарыг тогтоосон стандартыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж батлуулах;

10.1.26.улсын нөөцөд бүртгэгдсэн рашааныг эмчилгээ-сувилгаа, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглах талаар дүгнэлт гаргах;

10.1.27.хадлан, бэлчээр, тариаланг усжуулах инженерийн хийцтэй услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд мэргэжлийн дүгнэлт хийж, байгаль орчны болон, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

10.1.28.гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны сан бүхий газарт ус, усан орчинтой холбоотой шинжилгээ, судалгаа явуулах эсэх талаар шийдвэр гаргах;

10.1.29.усны чанарын болон хаягдал усны стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батлах;”

2 дугаар зүйл.Усны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь хэсгийн “Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 4.10 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.3, 5.5 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4, 7.5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.1.4, 17.1.11 дэх заалт, 18 дугаар зүйлийн, 18.1.1, 18.1.2, 18.1.5 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.4, 28.7, 28.15 дахь хэсгийн “усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалтын дугаарыг “10.1.30” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Усны тухай хуулийн 16 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1 дэх хэсгийн “хөдөлмөр эрхлэлтийн болон” гэснийг “хөдөлмөрийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.2 дахь хэсгийн “болон хэрэгжүүлэгч” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 30.1.13-30.1.17 дахь заалт нэмсүгэй:

“30.1.13.хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих, хэрэгжилтийг тайлагнах;

30.1.14.хөдөлмөр эрхлэлтийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, төлөв байдлын болон ажиллах хүчний ур чадварын хэрэгцээний судалгааг тодорхой давтамжтайгаар хийх, мэргэшсэн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх, хэтийн тооцооллын загвар боловсруулах, бодлого зохицуулалтын шийдвэрийн талаар санал гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах, бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргах;

30.1.15.хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;



30.1.16.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг бүрдүүлэх, хөрөнгийн хуваарилалтын төслийг боловсруулах, батлуулах, хөрөнгийг баталсан хуваарийн дагуу зарцуулах, хяналт тавих, тайлагнах;

30.1.17.аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн бирж, гадаадад ажиллах хүч илгээх болон гадаадаас ажиллах хүч авахад зуучлах байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;”

2 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “бодлого эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.6, 11.7 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “хөдөлмөрийн асуудал эрхэлсэн” гэснийг “хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн” гэж, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллагын даргатай” гэснийг “Засгийн газрын гишүүнтэй” гэж, “төрийн захиргааны байгууллагын дарга” гэснийг “Засгийн газрын гишүүн” гэж, 29.7 дахь хэсгийн “төв байгууллагын дарга” гэснийг “асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 30 дугаар зүйлийн 30.1.13 дахь заалтын дугаарыг “30.1.18” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, 11.7 дахь хэсгийн “энэ хуулийн 29.1-д заасан” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсгийн “Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага,” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2, 29.8 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх төрийн бодлого, Засгийн газрын болон энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэрийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.”

3 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “санхүү, боловсролын” гэснийг “санхүүгийн” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 10.3, 10.4 дэх хэсэг нэмсүгэй:

“10.3.Төрийн захиргааны төв байгууллагын харьяанд төмөр замын тээврийн хяналтын алба, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв ажиллана.

10.4.Төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ сургалт, судалгаа шинжилгээний байгууллагатай байж болно.”

2 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 16.4, 16.7 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.8 дахь хэсэг, 27.10 дахь хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа, 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсгийн “Төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.1.Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.төмөр замын тээврийн талаарх хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;

10.1.2.төмөр замын тээврийн салбар дахь төрийн өмчийн ашиглалт болон төрийн захиалгаар хийгдэх тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагаанд төрийн төлөөллийг хууль, олон улсын гэрээнд заасны дагуу хэрэгжүүлэх;

10.1.3.төмөр замын тээврийн нийтлэг багц дүрмийг батлах;

10.1.4.төмөр замын тээврийн салбарт шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилгоор тариф, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, гэрээний өөрчлөлтийг хянаж, санал, дүгнэлт гаргах;



10.1.5.суурь бүтэц ашиглах, төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх болон суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

10.1.6.төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

10.1.7.төмөр замын объект, салбар замыг өргөтгөх, шинээр барих ажиллагаанд хяналт тавих;

10.1.8.төмөр замын тээврийн аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах;

10.1.9.төмөр замын техникийн осол, сүйрлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээчийг томилох;

10.1.10.төмөр замын тээврийн салбарт мөрдөх улсын стандартыг боловсруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батлах;

10.1.11.төмөр замын мэргэжлийн ажилтан ажиллах албан тушаалын жагсаалт, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажил, албан тушаалын жагсаалтыг батлах;

10.1.12.төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх;

10.1.13.төмөр замаар аюултай ачаа тээвэрлэх, ачиж буулгах, хадгалах журмыг Тагнуулын ерөнхий газартай хамтран батлах;

10.1.14.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын төрийн тэргүүн зэрэг төрийн өндөр албан тушаалтны зорчих тусгай галт тэрэгний аялах журмыг Тагнуулын ерөнхий газартай зөвшилцөн батлах;

10.1.15.төмөр замын олон улсын хамтын ажиллагаанд Монгол Улсыг төлөөлөх;

10.1.16.зарим төрлийн /зорчигч, шуудан, улс орны эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой ачааны г.м./ тээвэрлэлтэд давуу байдал олгох;

10.1.17.тусгай тээвэрлэлт болон цэргийн тээвэрлэлт гүйцэтгэх журмыг эрх бүхий байгууллагатай зөвшилцөн батлах;

10.1.18.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх."



4 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллагын даргын” гэснийг “төрийн захиргааны төв байгууллагын” гэж, 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсгийн “төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв” гэснийг “эрх бүхий” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Төмөр замын тээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 11 дүгээр зүйл:

**“11 дүгээр зүйл.Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн
төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх**

11.1.Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

11.1.2.жижиг, дунд үйлдвэрийн салбарт улсын төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг нэгдсэн удирдлага, бодлогоор хангах;



11.1.3.жигжиг, дунд үйлдвэрийн тэргүүлэх ач холбогдол бүхий салбар, чиглэлийн талаар санал боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;

11.1.4.жигжиг, дунд үйлдвэр эрхлэгчид үзүүлэх төрийн үйлчилгээг нээлттэй, шуурхай хүргэх, шат дамжлагыг багасгах, хяналт шалгалт, бүртгэл, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээ авах санал боловсруулж зохих байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх;

11.1.5.жигжиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах;

11.1.6.жигжиг, дунд үйлдвэр эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, төрийн бус бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

11.1.7.жигжиг, дунд үйлдвэрийн талаар шаардлагатай судалгааг тогтмол явуулж, үр дүнг нийтэд мэдээлэх;

11.1.8.хуульд заасан бусад бүрэн эрх.”

2/21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг:

“21.1.Жигжиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг жигжиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, зохих журмын дагуу Засгийн газарт оруулж батлуулна.”

3 дугаар зүйл.Жигжиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний” гэснийг “Жигжиг, дунд үйлдвэрийн” гэж, мөн зүйлийн 20.2 дахь хэсэг, 20.2.6 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “үйлдвэр, худалдаа, үйлчилгээний” гэснийг “жигжиг, дунд үйлдвэрийн” гэж, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллагын дарга” гэснийг “Засгийн газрын гишүүн” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 8 дугаар зүйлийн 8.1.6-8.1.9 дэх заалт:

“8.1.6.бүх насны ангиллын биеийн тамир-чийрэгжүүлэлтийн нормативыг боловсруулан батлах;

8.1.7.улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах эрх олгох;

8.1.8.биеийн тамир, спортын улсын мэдээллийн санг бүрдүүлэх;

8.1.9.биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулах;”

2/ 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг:

“8.2.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, нийслэл, дүүрэгт биеийн тамир, спортын хороо, суманд биеийн тамир, спортын орон тооны бус арга зүйчтэй байна.”

2 дугаар зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2-18.4 дэх хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “9.3” гэснийг “8.1.6-8.1.9” гэж, 20.4 дэх хэсгийн “Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг” гэснийг “Аймаг” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын дугаарыг “8.1.10” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Биеийн тамир, спортын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “болон” гэсний өмнөх “төрийн захиргааны” гэснийг,



20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Биеийн тамир, спортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА
ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Ерөнхий сайд, орлогч дарга нь бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга” гэж, 6.5 дахь хэсгийн “Шадар сайдын ажлын алба” гэснийг “Засгийн газрын Хэрэг эрхлэх газар” гэж, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “Монгол Улсын Ерөнхий сайдын” гэснийг “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын” гэж, 7.6 дахь хэсгийн “Ерөнхий сайд” гэснийг “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга” гэж, 13 дугаар зүйлийн гарчгийг “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын бүрэн эрх” гэж, 13.1 дэх хэсгийн “Бүс нутгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга” гэж, мөн зүйлийн 13.1.5 дахь заалтын “хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах” гэснийг “хороог удирдах” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

СТРАТЕГИЙН АЧ ХОЛБОГДОЛ БҮХИЙ САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА АЖ АХУЙН НЭГЖИД ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.3, 7.4, 7.6 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “Хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “Хууль зүйн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13¹ дугаар зүйлийн 13^{1.1} дэх хэсгийн 13^{1.1.3} дахь заалтын “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**“ЗАМЫН-ҮҮД” ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ БҮСИЙН
ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.“Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “соёл,” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.3 дахь хэсэг, 117 дугаар зүйлийн 117.4 дэх хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Инновацийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 7.1 дэх хэсэг, 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийн “Үндэсний хөгжил, шинэтгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа, 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.4, 13.8, 13.15 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.3.1, 20.3.2 дахь заалтын “үндэсний хөгжил, шинэтгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.7 дахь хэсгийн “Хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “Хууль зүйн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Жолоочийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийн “дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.2, 16.5 дахь хэсгийн “хууль зүй, дотоод хэргийн” гэснийг “хууль зүйн” гэж тус тус өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсгийн “Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага”, 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын “төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Чөлөөт бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсгийн “Монгол Улсын Ерөнхий” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Ерөнхий” гэснийг “эдийн засгийн хөгжлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ
ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4.2 дахь заалтын “санхүү, төсвийн” гэсний өмнө “эдийн засгийн хөгжлийн болон” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “Төлөөлөн удирдах зөвлөл болон” гэсний дараа “эдийн засгийн хөгжлийн, ” гэж, “саналыг” гэсний дараа “тус тус” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийн “Санхүү, төсвийн” гэснийг “Эдийн засгийн хөгжлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “санхүү, төсвийн” гэсний өмнө “эдийн засгийн хөгжлийн болон” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын дэд даргаар Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогтыг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Өргөдлийн байнгын хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Өргөдлийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Раднаагийн Бурмааг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар
хот

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийг хавсралтаар баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай” Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 43 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

Монгол Улсын Их Хурлын 2012 оны
14 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТОГТООЛЦОО, БҮТЦИЙН ЕРӨНХИЙ БҮДҮҮВЧ

Эрхлэх асуудлын хүрээ, харьяалал	Засгийн газрын тохируулагч агентлаг	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд	1.Тагнуулын ерөнхий газар 2.Цөмийн энергийн газар 3.Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	
Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд	4.Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 5.Онцгой байдлын ерөнхий газар 6.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар 7.Стандартчилал, хэмжил зүйн газар	1.Худалдан авах ажиллагааны газар 2.Оюуны өмчийн газар
Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд		



Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		3.Цаг уур, орчны шинжилгээний газар
Гадаад харилцааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		4.Гаалийн ерөнхий газар 5.Татварын ерөнхий газар
Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	8.Цагдаагийн ерөнхий газар 9.Хил хамгаалах ерөнхий газар	6.Улсын бүртгэлийн ерөнхий газар 7.Архивын ерөнхий газар 8.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар 9.Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газар
Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		10.Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд	10.Зэвсэгт хүчний жанжин штаб	
Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		11.Иргэний нисэхийн ерөнхий газар
Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Уул уурхайн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		12.Ашигт малтмалын газар 13.Газрын тосны газар
Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд	11.Төрийн өмчийн хороо	14.Мал эмнэлэг, үржлийн газар
Хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд		15.Нийгмийн даатгалын ерөнхий газар 16.Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар 17.Хүүхдийн төлөө үндэсний газар



Эдийн засгийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээнд		
Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд		

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24.6 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого” батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 34 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого”-ын 5.7 дахь заалтын “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого батлах тухай тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24.6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1. “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого” батлах тухай Улсын Их Хурлын 2009 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 64 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого”-ын 7.1 дэх заалтын “төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж өөрчилсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 17

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын зарим
гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын гишүүн, сайдаар дор дурдсан хүмүүсийг томилсугай:

1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар Чимэдийн Сайханбилэгийг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдаар Лувсанвандангийн Болдыг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүйн сайдаар Хишигдэмбэрэлийн Тэмүүжинг;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдаар Цэвэлмаагийн Баярсайханыг;



5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Батлан хамгаалахын сайдаар Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнийг;

6/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Боловсрол, шинжлэх ухааны сайдаар Лувсаннъямын Гантөмөрийг;

7/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдаар Амаржаргалын Гансүхийг;

8/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Соёл, спорт, аялал жуулчлалын сайдаар Цэдэвдамбын Оюунгэрэлийг;

9/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Уул уурхайн сайдаар Даваажавын Ганхуягийг;

10/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдаар Халтмаагийн Баттулгыг;

11/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хөдөлмөрийн сайдаар Ядамсүрэнгийн Санжмятавыг;

12/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдаар Содномзундуйн Эрдэнийг;

13/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эдийн засгийн хөгжлийн сайдаар Нямжавын Батбаярыг.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын гишүүдийг
үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай**

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-сайд нарыг шинээр томилсонтой холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Дор дурдсан хүмүүсийг Засгийн газрын гишүүн, сайдын үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй:

1/Миеэгомбын Энхболдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын Шадар сайдын;

2/Гомбожавын Занданшатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Гадаад харилцааны сайдын;

3/Дамдингийн Хаянхярвааг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Сангийн сайдын;

4/Цэндийн Нямдоржийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын;

5/Дамдингийн Цогтбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын;

6/Жадамбын Энхбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдын;

7/Ёндонгийн Отгонбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын;

8/Цэдэвийн Дашдоржийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын;

9/Төгсжаргалын Гандийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын;

10/Түнжингийн Бадамжунайг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын;

11/Дашдоржийн Зоригтыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын;

12/Нямдаваагийн Хүрэлбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайдын;

13/Чимэдийн Хүрэлбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын.



2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Их Хурлын дэд даргын
үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2 дахь заалт, өөрийнх нь гаргасан хүсэлтийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Чүлтэмийн Улааныг Монгол Улсын Их Хурлын дэд даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 20

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын зарим
гишүүнийг томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газрын гишүүн, сайдаар дор дурдсан хүмүүсийг томилсугай:



1/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын Шадар сайдаар Дэндэвийн Тэрбишдагвыг;

2/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдаар Санжаасүрэнгийн Оюуныг;

3/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдаар Чүлтэмийн Улааныг;

4/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдаар Мишигийн Сономпилийг;

5/Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрүүл мэндийн сайдаар Нацагийн Удвалыг.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.3.2 дахь заалт, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын дэд даргаар МАХН-МҮАН-ын “Шударга Ёс” эвслийн бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Логийн Цогийг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Мишигийн Сономпилийг Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Ринчиннямын Амаржаргалыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Шаравдоржийн Түвдэндоржийг Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Октябрийн Баасанхүүг Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Октябрийн Баасанхүүг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Мишигийн Сономпил, Жаргалтулгын Эрдэнэбат нарыг Төсвийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 08 дугаар
сарын 21-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.3 дахь заалт, 24 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Их Хурлын дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо:

- 1.Гарьдхүүгийн Баярсайхан
- 2.Лувсанвандангийн Болд
- 3.Батсүхийн Наранхүү
- 4.Цэдэвдамбын Оюунгэрэл
- 5.Дэндэвийн Тэрбишдагва
- 6.Лувсангийн Эрдэнэчимэг

2/Ёс зүйн дэд хороо:

- 1.Мигэгдоржийн Батчимэг
- 2.Жалбасүрэнгийн Батзандан
- 3.Зангадын Баянсэлэнгэ
- 4.Раднаагийн Бурмаа
- 5.Батсүхийн Наранхүү
- 6.Шаравдоржийн Түвдэндорж
- 7.Дэндэвийн Тэрбишдагва
- 8.Дондогдоржийн Эрдэнэбат

3/ Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо:

- 1.Догсомын Батцогт
- 2.Хаянгаагийн Болорчулуун
- 3.Дашдондогийн Ганбат
- 4.Даваажавын Ганхуяг
- 5.Самбуугийн Дэмбэрэл
- 6.Салдангийн Одонтуяа
- 7.Дэндэвийн Тэрбишдагва
- 8.Гантөмөрийн Уянга

4/ Мянганы хөгжлийн зорилтууд болон ядуурлыг бууруулах асуудлын дэд хороо:

- 1.Сайнхүүгийн Ганбаатар
- 2.Лувсаннъямын Гантөмөр
- 3.Самбуугийн Дэмбэрэл
- 4.Салдангийн Одонтуяа
- 5.Ядамсүрэнгийн Санжмятав



- 6.Гантөмөрийн Уянга
- 7.Содномзундуйн Эрдэнэ
- 8.Лувсангийн Эрдэнэчимэг

5/ Нутгийн удирдлагын дэд хороо:

- 1.Агыпарын Бакей
- 2.Жалбасүрэнгийн Батзандан
- 3.Догсомын Батцогт
- 4.Намдагийн Батцэрэг
- 5.Мигэددоржийн Батчимэг
- 6.Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ
- 7.Раднаасүмбэрэлийн Гочигдорж

6/Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо:

- 1.Жалбасүрэнгийн Батзандан
- 2.Мигэددоржийн Батчимэг
- 3.Раднаагийн Бурмаа
- 4.Батсүхийн Наранхүү
- 5.Логийн Цог

7/Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо:

- 1.Раднаасүмбэрэлийн Гончигдорж
- 2.Дамдингийн Дэмбэрэл
- 3.Данзангийн Лүндээжанцан
- 4.Санжаасүрэнгийн Оюун
- 5.Чүлтэмийн Улаан

8/ Төсвийн зарлагын хяналтын дэд хороо:

- 1.Сангажавын Баярцогт
- 2.Сайнхүүгийн Ганбаатар
- 3.Лувсанямын Гантөмөр
- 4.Даваажавын Ганхуяг
- 5.Мөнхчулууны Зоригт
- 6.Батсүхийн Наранхүү
- 7.Чүлтэмийн Улаан
- 8.Жаргалтулгын Эрдэнэбат



9/ Тусгай хяналтын дэд хороо:

- 1.Октябрийн Баасанхүү
- 2.Мигэйдоржийн Батчимэг
- 3.Раднаасүмбэрэлийн Гончигдорж

10/ Хүний эрхийн дэд хороо:

- 1.Октябрийн Баасанхүү
- 2.Жалбасүрэнгийн Батзандан
- 3.Халтмаагийн Баттулга
- 4.Зангадын Баянсэлэнгэ
- 5.Лувсанвандангийн Болд
- 6.Дашдондогийн Ганбат
- 7.Хишигдэмбэрэлийн Тэмүүжин
- 8.Содномзундуйн Эрдэнэ

2.Энэ тогтоолыг 2012 оны 8 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 6 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 200

Улаанбаатар
хот

**Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх
талаар авах зарим арга хэмжээний тухай**

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын 2011 оны 57 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Д.Хаянхяраад даалгасугай:

1.1. Монгол Улсын хэмжээнд өмчийн бүх эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төлөвлөлт, бүртгэл мэдээлэл, бодит гүйцэтгэлийн хяналт-шинжилгээний цахим удирдлагын систем нэвтрүүлэх;



1.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгөөр худалдан авах зарим төрлийн бараа бүтээгдэхүүнийг ерөнхий гэрээгээр гүйцэтгүүлэх;

1.3. Хөрөнгө оруулалтын тухай, Гэрээний хариуцлагын тухай хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

1.4. тендерийн дундаж үнийг тооцон ашигладаг аргачлалыг худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд мөрдүүлэх;

1.5. төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн судалгаа хийх, зураг төсөл, төсөв зохиох, техникийн нөхцөл болон холбогдох зөвшөөрөл авахад шаардагдах үнэлгээ, зардлыг урьдчилан тооцож төлөвлөж байх.

2. Хүний нөөц, ажиллах хүчний хөгжлийн иж бүрэн тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр тодорхой санал боловсруулан Засгийн газарт оруулахыг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (Ч.Хашчулуун)-нд даалгасугай.

3. Хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дагдорж, Эрдэс, баялаг эрчим хүчний сайд Д.Зоригт, Төрийн өмчийн хороо (Б.Заяабал)-нд тус тус үүрэг болгосугай:

3.1. барилга, байгууламжийн угсралт, их засварын ажлын норм, стандартыг олон улсын түвшинд хүргэн шинэчлэх, төсөв зохиох аргачлалд тухайн жилийн үнийн индексийг тооцсон итгэлцүүрийг тусган мөрдүүлэх, барилгын гол нэрийн материалын зах зээлийн дундаж үнийг ил тод мэдээлдэг тогтолцоог нэвтрүүлэх;

3.2. барилга байгууламжийн ажлын зураг төслийн барилга архитектур болон барилга бүтээцийн хэсгийн магадлалыг эх загвар зурагт хийж байх, зураг, төсөв, техник-эдийн засгийн үндэслэлийн боловсруулалтыг сайжруулах, гүйцэтгэсэн ажлын үр дүнг харгалзан ажлын зөвшөөрөл, мэргэжлийн зэрэг олгох, хариуцлага тооцох тогтолцоог нэвтрүүлэх;

3.3. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх аж ахуйн нэгжийг чадваржуулах, зэрэглэх, хорших, төрөлжүүлэн



мэргэшүүлэх зэрэг олон улсад үр дүнтэй нь тогтоогдсон зохион байгуулалт, менежментийн арга хэрэгслийг нэвтрүүлэх;

3.4. улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн ажлын зураг, төсөвт магадлал хийх албыг “Хот байгуулалт, барилгын зураг төслийн институт” Төрийн өмчит үйлдвэрийн газарт харьяалуулан аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулж, бүтэц орон тооны асуудлыг 2012 онд багтаан шийдвэрлүүлэх;

3.5. одоогийн орон тооны хязгаарт нь багтаан зохицуулалт хийх замаар Эрчим хүчний шинжлэх ухаан, судалгааны хүрээлэнг шинээр байгуулах, “Хот байгуулалт, барилгын зураг төслийн институт” Төрийн өмчит үйлдвэрийн газрын чиг үүрэгт салбарын эрдэм шинжилгээний судалгаа, туршилт явуулах, зураг төсөл, төсөвт магадлал хийх ажлыг хариуцуулах замаар техник, технологийн дэвшлийг эрчимтэй нэвтрүүлэх, инженерийн арга шийдлүүдийг боловсронгуй болгох, норм, норматив, стандартыг туршин нэвтрүүлэх, өртөг, зардлыг оновчтой тогтоох нөхцөлийг бүрдүүлэх;

3.6. яам, агентлаг, орон нутгийн захиргааны байгууллагын ажлын уялдааг ханган, хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналтыг зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллагаар гүйцэтгэдэг нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар дахь захиалагчийн хяналтыг зөвлөхийн үйлчилгээ хариуцсан алба болгон зохион байгуулах;

3.7. холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Барилга захиалагчийн албаны дүрмийг шинэчлэх арга хэмжээ авах.

4. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр нарт даалгасугай:

4.1. хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын нийгмийн баазыг бэлтгэх, иргэд, ялангуяа хүүхэд, залуучуудад хөдөлмөр бүтээлээр амьдрах сэтгэлгээг төлөвшүүлэх чиглэлийг сургалтын хөтөлбөрт тусгах, Үндэсний олон нийтийн радио, телевиз бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран мэдээлэл, танин мэдэхүй, гэгээрлийн арга хэмжээг зохион байгуулах;

4.2. Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургуулийн дэргэд өндөр технологи, зохион бүтээх, туршилт судалгааны орчин үеийн лаборатори байгуулах замаар оюуны хөрөнгө



оруулалтыг эрчимтэй ашиглах, нээлт бүтээл гаргах, инноваци нэвтрүүлэх, эх орны нөөц баялагийг боловсруулж ашиглах, олон улсын зах зээлд үнэлэгдэх үндэсний бүтээгдэхүүн бий болгох чиглэлээр эрдэмтэн судлаачдын гаргаж байгаа бодит санал санаачлагыг дэмжих, энэ ажилд Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгийг төвлөрүүлэх.

5. Барилгын материалын үйлдвэрлэлийн паркийг Улаанбаатар хотод хоёроос доошгүй, Бүсийн тулгуур төв хотод тус бүр нэгийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар зохион байгуулах арга хэмжээ авахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдорж, холбогдох аймгийн Засаг дарга нар болон нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаярт даалгасугай.

6. Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж байгаа барилга, байгууламжийн угсралтын технологи, зураг төсөл боловсруулалт, барилга, замын ажлын материалын орц, нормд тавих хяналтыг тухайн үе шат бүрт гүйцэтгэж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд байнгын хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

Д.ХАЯНХЯРВАА

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiiin_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 3.75

Индекс: 14003